

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах удитор: Б.Давааням

Утас:88095436 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/261  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ю.ЭНХЖАРГАЛ  
ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,419,172.2 мянган төгрөгийн авлагатай, 1,865,861.7 мянган төгрөгийн эм, тогтмол зардлын өглөгтэй гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 27,538.4 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлж 1 алдааг залруулж, 9 зөвлөмж өглөө.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 95.9 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,291,247,284.90</b>	<b>3,154,294,025.86</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>86,253,739.17</b>	<b>128,766,006.69</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	86,253,739.17	128,765,902.69
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	86,253,739.17	128,766,006.69
31211	Төрийн сангийн харилцах	86,253,739.17	128,765,902.69
31213	Арилжааны банкин дах харилцах	0.00	104.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,547,104,237.11</b>	<b>1,419,172,233.64</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,543,132,264.70	1,419,172,233.64
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,971,972.41	0
3351	Байгууллагаас авах авлага	1,237,672.41	0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,734,300.00	0
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0</b>	<b>14,330,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	0	14,330,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,657,889,308.62</b>	<b>1,592,025,785.53</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,030,192,962.05	902,916,625.31
35110	Тусгай зориулалттай материал	254,068,727.80	303,676,079.99
35130	Эм боох материал	776,124,234.25	599,240,545.32
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	627,696,346.57	689,109,160.22
35410	Бичиг хэргийн материал	1,099,150.00	927,230.00
35420	Аж ахуйн материал	105,571,935.01	163,393,585.09
35430	Сэлбэг хэрэгсэл	37,585,600.00	39,482,550.00
35440	Түлш, шатах тослох материал	2,092,790.00	1,850,355.90
35450	Барилгын засварын материал	5,593,650.00	8,572,900.00
35460	Хүнсний материал	17,115,337.00	17,027,500.00
35470	Бусад хангамжийн материал	458,637,884.56	457,855,039.23
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,522,587,432.45</b>	<b>17,975,776,574.52</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>17,522,587,432.45</b>	<b>17,975,776,574.52</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>16,396,674,307.53</b>	<b>16,850,199,074.63</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,190,774,265.13	11,062,178,750.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,585,074,460.32	-2,993,963,202.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,201,787,595.20	1,231,499,595.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-445,548,745.99	-589,281,336.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,331,584,608.54	14,646,269,108.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,707,286,308.61	-7,342,673,183.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	660,950,880.67	666,709,780.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-307,678,269.53	-360,357,516.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	154,208,413.40	637,043,975.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-97,043,670.96	-107,226,895.98
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,125,913,124.92</b>	<b>1,125,577,499.89</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	1,128,432,500.00	1,128,432,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,519,375.08	-2,855,000.11
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>20,813,834,717.35</b>	<b>21,130,070,600.38</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,473,450,366.04</b>	<b>1,866,199,178.74</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,473,450,366.04</b>	<b>1,866,199,178.74</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,473,450,366.04	1,866,199,178.74
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	337,494.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,473,450,366.04	1,865,861,684.54
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,340,384,351.31</b>	<b>19,263,871,421.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>19,340,384,351.31</b>	<b>19,263,871,317.64</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,126,931,228.10	7,126,931,228.10

51101	Өмч: - төрийн	7,126,931,228.10	7,126,931,228.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>7,794,353,809.49</b>	<b>7,717,840,879.82</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	7,794,353,809.49	7,794,353,809.49
51220	Тайлант үеийн үр дүн	0	-76,512,929.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419,099,313.72	4,419,099,313.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>20,813,834,717.35</b>	<b>21,130,070,600.38</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>26,326,571,915.35</b>	<b>27,554,585,304.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,076,723,238.35</b>	<b>5,221,065,430.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,076,723,238.35	5,507,206,828.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,076,723,238.35	5,507,206,828.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	834,825,036.00	1,143,104,520.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	256,346,200.00	1,266,083,236.00
1200045	Үнэ төлбөргүй авсан ҮХ	3,720,212,265.34	2,681,518,446.72
120005	Үнэ төлбөргүй авсан БМ	265,339,737.01	416,500,625.39
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,249,848,677.00</b>	<b>22,047,378,476.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,732,034,100.00	1,556,551,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,732,034,100.00	1,556,551,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	19,517,814,577.00	20,490,826,976.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,517,814,577.00	20,490,826,976.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>24,595,257,744.05</b>	<b>27,630,569,567.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,595,257,744.05</b>	<b>27,630,569,567.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	24,332,204,146.18	26,682,682,400.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	12,398,451,105.84	14,022,225,034.39
210101	Үндсэн цалин	5,744,381,291.45	6,637,265,191.35
210102	Нэмэгдэл	4,725,537,201.16	5,598,396,814.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	689,055,872.00	743,204,636.72
210104	Урамшуулал	1,239,476,741.23	1,043,358,391.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,598,681,863.40	1,804,707,109.83
210201	Тэтгэврийн даатгал	1,193,466,252.01	1,231,187,553.38
210202	Тэтгэмжийн даатгал	101,230,700.00	141,849,155.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,908,111.39	112,887,181.60
210204	Ажилгүйдлийн даатгал	50,615,400.00	62,916,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	202,461,400.00	255,867,018.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,571,384,717.49	2,273,209,661.36
210301	Гэрэл, цахилгаан	171,758,885.81	223,528,476.97
210302	Түлш, халаалт	877,692,564.33	1,531,345,576.67
210303	Цэвэр, бохир ус	521,933,267.35	518,335,607.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	913,758,826.91	296,992,809.05
210401	Бичиг хэрэг	16,706,045.00	12,757,600.00
210402	Тээвэр, шатахуун	98,784,410.60	87,671,491.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,183,270.00	25,041,052.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,750,000.00	13,030,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	67,751,595.71	57,771,686.29
210408	Бараа материал акталсны зардал	699,583,505.60	100,720,979.23

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,747,834,602.07	5,618,615,323.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,552,739,204.37	5,404,246,665.30
210502	Хоол, хүнс	195,095,397.70	214,368,658.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	437,156,690.00	139,549,690.00
210604	Урсгал засвар	437,156,690.00	139,549,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	36,708,400.00	43,159,200.00
210702	Дотоод албан томилолт	36,708,400.00	43,159,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	105,603,038.00	207,412,219.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,767,181.00	167,673,763.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,159,400.00	6,159,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	540,033.00	621,032.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	242,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	220,000.00
210807	Газрын төлбөр	6,674,102.00	6,901,904.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,560,322.00	22,846,120.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,522,624,902.47	2,276,811,353.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,474,200.00	6,149,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	110,515.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,501,150,702.47	2,270,551,638.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	263,053,597.87	947,887,166.74
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	252,283,500.00	947,887,066.74
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	503,706,036.74
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	228,450,000.00	431,196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,833,500.00	12,985,030.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	10,770,097.87	100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,770,097.87	100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,731,314,171.30</b>	<b>-75,984,367.27</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	39,444,769.96	528,666.40
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	39,444,769.96	528,666.40
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)</b>	-39,444,769.96	-528,666.40
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,691,869,401.34</b>	<b>-76,512,919.67</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>21,384,612,468.30</b>	<b>24,595,676,434.74</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,091,691,236.00</b>	<b>2,424,337,927.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,091,691,236.00	2,424,337,927.68
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,091,691,236.00	2,424,337,927.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	835,345,036.00	1,158,254,691.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	256,346,200.00	1,266,083,236.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>20,292,921,232.30</b>	<b>22,171,338,507.06</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,732,034,100.00	1,556,551,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,732,034,100.00	1,556,551,500.00

<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	18,560,887,132.30	20,614,787,007.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,560,887,132.30	20,614,787,007.06
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>21,295,071,535.64</b>	<b>24,510,413,167.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,295,071,535.64</b>	<b>24,510,413,167.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,032,017,937.77</b>	<b>23,562,526,000.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>12,372,929,169.04</b>	<b>13,997,275,380.19</b>
210101	Үндсэн цалин	5,718,859,354.65	6,612,314,663.49
210102	Нэмэгдэл	4,725,537,201.16	5,598,397,688.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	689,055,872.00	743,204,636.72
210104	Урамшуулал	1,239,476,741.23	1,043,358,391.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,598,681,863.40</b>	<b>1,804,707,109.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,193,466,252.01	1,231,187,553.38
210202	Тэтгэмжийн даатгал	101,230,700.00	141,849,155.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,908,111.39	112,887,181.60
210204	Ажилгүйдлийн даатгал	50,615,400.00	62,916,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	202,461,400.00	255,867,018.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,192,441,972.63</b>	<b>1,541,968,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	171,758,885.81	191,665,139.41
210302	Түлш, халаалт	1,365,663,503.47	996,001,899.87
210303	Цэвэр, бохир ус	655,019,583.35	354,301,260.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>217,745,976.00</b>	<b>197,412,917.20</b>
210401	Бичиг хэрэг	17,185,885.00	12,720,000.00
210402	Тээвэр, шатахуун	99,274,328.00	87,457,257.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,183,270.00	25,041,052.23
210404	Ном, хэвлэл	00.00	270,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,750,000.00	13,030,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,352,493.00	58,894,607.77
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,029,363,793.70</b>	<b>5,628,564,568.53</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,784,399,768.70	5,291,320,087.53
210502	Хоол, хүнс	224,964,025.00	237,178,981.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000,000.00	100,065,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>458,180,890.00</b>	<b>135,606,225.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	595,000.00	24,720,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	780,000.00
210604	Урсгал засвар	457,585,890.00	110,106,225.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>36,708,400.00</b>	<b>43,468,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	36,708,400.00	43,468,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>104,225,688.00</b>	<b>207,374,099.73</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,567,181.00	167,673,763.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,159,400.00	6,159,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	540,033.00	621,032.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	242,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	220,000.00
210807	Газрын төлбөр	6,674,102.00	6,901,904.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,382,972.00	22,808,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,740,185.00</b>	<b>6,149,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,740,185.00	6,149,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>263,053,597.87</b>	<b>947,887,166.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>252,283,500.00</b>	<b>947,887,066.74</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	503,706,036.74
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	228,450,000.00	431,196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,833,500.00	12,985,030.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	10,770,097.87	100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,770,097.87	100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>89,540,932.66</b>	<b>85,263,267.52</b>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,000,000.00</b>	<b>42,751,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,000,000.00</b>	<b>42,751,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,000,000.00	42,751,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,000,000.00	42,751,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-11,000,000.00</b>	<b>-42,751,000.00</b>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	78,540,932.66	42,512,267.52
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	11,647,106.51	86,253,739.17
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	86,253,739.17	128,766,006.69

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,126,931,228.10</b>	<b>4,419,099,313.72</b>	<b>6,102,484,408.15</b>	<b>17,648,514,949.97</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,691,869,401.34	1,691,869,401.34
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,126,931,228.10</b>	<b>4,419,099,313.72</b>	<b>7,794,353,809.49</b>	<b>19,340,384,351.31</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-76,512,919.67	-76,512,919.67
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,126,931,228.10</b>	<b>4,419,099,313.72</b>	<b>7,717,840,879.82</b>	<b>19,263,871,421.64</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>23,734,576,000.00</b>	<b>23,039,124,830.74</b>	<b>695,451,169.26</b>	<b>97.1</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>3,059,068,300.00</b>	<b>2,424,337,823.68</b>	<b>634,730,476.32</b>	<b>79.3</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,059,068,300.00</b>	<b>2,424,337,823.68</b>	<b>634,730,476.32</b>	<b>79.3</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,162,342,300.00	1,158,254,691.68	4,087,608.32	99.6
120009	Бусад орлого	1,896,726,000.00	1,266,083,132.00	630,642,868.00	66.8

<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>20,675,507,700.00</b>	<b>20,614,787,007.06</b>	<b>60,720,692.94</b>	<b>99.7</b>
<b>122001</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>20,544,884,700.00</b>	<b>20,614,787,007.06</b>	<b>(69,902,307.06)</b>	<b>100.3</b>
122005	Төсвөөс санхүүжих	130,623,000.00	0.00	130,623,000.00	0.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>23,820,829,800.00</b>	<b>22,996,612,667.22</b>	<b>824,217,132.78</b>	<b>96.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,820,829,800.00</b>	<b>22,996,612,667.22</b>	<b>824,217,132.78</b>	<b>96.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>22,123,663,200.00</b>	<b>22,048,725,600.48</b>	<b>74,937,599.52</b>	<b>99.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>14,058,392,000.00</b>	<b>13,997,275,380.19</b>	<b>61,116,619.81</b>	<b>99.6</b>
210101	Үндсэн цалин	6,729,716,600.00	6,612,314,663.49	117,401,936.51	98.3
210102	Нэмэгдэл	5,650,723,800.00	5,598,397,688.58	52,326,111.42	99.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	553,460,100.00	743,204,636.72	(189,744,536.72)	134.3
210104	Урамшуулал	1,124,491,500.00	1,043,358,391.40	81,133,108.60	92.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,806,728,300.00</b>	<b>1,804,707,109.83</b>	<b>2,021,190.17</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,303,399,600.00	1,231,187,553.38	72,212,046.62	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	125,832,200.00	141,849,155.90	(16,016,955.90)	112.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	62,916,200.00	112,887,181.60	(49,970,981.60)	179.4
210204	Ажилгүйдлийн даатгал	62,916,200.00	62,916,200.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	251,664,100.00	255,867,018.95	(4,202,918.95)	101.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>199,914,000.00</b>	<b>197,412,917.20</b>	<b>2,501,082.80</b>	<b>98.7</b>
210401	Бичиг хэрэг	15,333,000.00	12,720,000.00	2,613,000.00	83.0
210402	Тээвэр шатахуун	86,189,000.00	87,457,257.20	(1,268,257.20)	101.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,464,000.00	25,041,052.23	(2,577,052.23)	111.5
210404	ном хэвлэл	600,000.00	270,000.00	330,000.00	45.0
210405	Хог хаягдал зайлуулах	11,328,000.00	13,030,000.00	(1,702,000.00)	115.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,000,000.00	58,894,607.77	5,105,392.23	92.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,599,033,500.00</b>	<b>5,628,564,568.53</b>	<b>(29,531,068.53)</b>	<b>100.5</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,254,033,500.00	5,291,320,087.53	(37,286,587.53)	100.7
210502	Хоол, хүнс	250,000,000.00	237,178,981.00	12,821,019.00	94.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,000,000.00	100,065,500.00	(5,065,500.00)	105.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>163,740,000.00</b>	<b>162,308,125.00</b>	<b>1,431,875.00</b>	<b>99.1</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	68,740,000.00	66,785,000.00	1,955,000.00	97.2
210604	Урсгал засвар	95,000,000.00	95,523,125.00	(523,125.00)	100.6
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>43,604,000.00</b>	<b>43,468,200.00</b>	<b>135,800.00</b>	<b>99.7</b>
210702	Дотоод албан томилолт	43,604,000.00	43,468,200.00	135,800.00	99.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>242,251,400.00</b>	<b>207,374,099.73</b>	<b>34,877,300.27</b>	<b>85.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,315,000.00	197,603,667.73	34,711,332.27	85.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2660000	40,000.00	98.5
210803	Даатгалын үйлчилгээ	7,236,400.00	7110432	125,968.00	98.3

210804	Тээврийн хэрэгслийн татвар	714,000.00	621,032.00	92,968.00	87.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	330,000.00	33,000.00	90.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,000.00	220,000.00	440,000.00	33.3
210807	Газрын төлбөр	6,934,000.00	6,901,904.00	32,096.00	99.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,000,000.00	22,808,000.00	2,192,000.00	91.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>7,615,200.00</b>	<b>2,384,800.00</b>	<b>76.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	7,615,200.00	2,384,800.00	76.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,697,166,600.00</b>	<b>947,887,066.74</b>	<b>749,279,533.26</b>	<b>55.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,697,166,600.00</b>	<b>947,887,066.74</b>	<b>749,279,533.26</b>	<b>55.9</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	607,044,600.00	503,706,036.74	103,338,563.26	83.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,066,863,000.00	431,196,000.00	635,667,000.00	40.4
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	23,259,000	12,985,030	10,273,970	55.8
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-86,253,800.00</b>	<b>42,512,163.52</b>		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,253,800.00	-42,512,163.52		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	86,253,800.00	-42,512,163.52		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		86,253,739.17		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	128,765,902.69		

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

				/төгрөгөөр/	
Код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,556,551,500.00</b>	<b>1,556,551,400.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
122	Тусламжийн орлого	1,556,551,500.00	1,556,551,400.00	100.00	100.0
122005	Төсвөөс санхүүжих	1,556,551,500.00	1,556,551,400.00	100.00	100.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,556,551,500.00</b>	<b>1,556,551,400.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,556,551,500.00</b>	<b>1,556,551,400.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,556,551,500.00</b>	<b>1,556,551,400.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,541,968,400.00</b>	<b>1,541,968,300.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	191,665,000.00	191,665,139.41	-139.41	100.0
210302	Түлш, халаалт	996,001,900.00	996,001,899.87	0.13	100.0
210303	Цэвэр, бохир ус	354,301,500.00	354,301,260.72	239.28	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,583,100.00</b>	<b>14,583,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	14,583,100.00	14,583,100.00	0.00	100.0

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	0.00		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0.00	0.00		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,538.4 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлснээс 1 алдааг залруулж, 9 зөвлөмж өглөө.

#### 3.1 Залруулсан алдаа

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 27,538.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 393,524.1 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт 1:

Тайлант жилд акталж данснаас хассан эмийн жагсаалтад 2023 онд акталсан 3,108.2 мянган төгрөгийн эмийг оруулсан байгаа нь бараа материалыг актлах талаар гарсан Нэгдсэн эмнэлгийн захирлын тушаалд актлах бараа материалын нэр төрөл, үнийн дүн, хавсралтын хуудас, хавсралт тус бүрийн үнийн дүн зэргийг тусгаагүй, дүнг тулгах боломжгүй байгаатай, нөгөө талаас эмийн тооллого, үлдэгдлийн тулгалт хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө акталж данснаас хасахтай холбоотой шийдвэрт нэр төрөл, үнийн дүнг тодорхой тусгаж, нягтлан бодох бүртгэлд тусгасан дүнтэй тулгаж тааруулж байх.

###### Илрүүлэлт 2:

Хагас жилийн тооллого болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийсэн хяналтын тооллогоор 3,990.4 мянган төгрөгийн эм илүүдсэн нь эмийн бүртгэл,

зарцуулалт, буцаалтад тавих хяналт хангалтгүй, ажил гүйлгээг тухай бүрт нь бүртгэхгүй байгааг харуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эмийн орлого, зарлага, тасгийн буцаалтын гүйлгээг тухай бүрд нь бүртгэж, үлдэгдлийг тулгаж, тааруулж байх, дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.

**Илрүүлэлт 3:**

Нэгээс дээш жил байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах 6,347.5 мянган төгрөгийн хангамжийн материалыг эзэмшиж буй ажилтанд картлаагүй, шууд зарлагдаж, тайлант үеийн зарцуулалтаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын үйл ажиллагаанд нэгээс дээш жилийн хугацаанд ашиглагдах хөрөнгүүдийг эзэмшигч албан тушаалтанд эд хөрөнгийн картаар эзэмшүүлж, ашиглалтад хяналт тавих.

**2. Анхан шатны баримттай холбоотой асуудал.**

**Илрүүлэлт :**

Нэгдсэн эмнэлгийн эмийн зарцуулалт нь E-HEALT эрүүл мэндийн цахим программаар хийгдэж байгаа бөгөөд эмийн захиалгын хуудсыг үндэслэн тасгуудад эм олгохдоо, тасгаас буцааж авахдаа хүлээн авсан, хүлээлгэн өгсөн, хянасан ажилтнаар гарын үсэг зуруулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагын гүйлгээний товчоог хийхдээ үйлдсэн, хянасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр анхан шатны баримтаар зарлага гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйлгээг бүртгэх

**3. Мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт 1 :**

Тус эмнэлэгт яаралтай үед зарцуулах жижиг мөнгөн сангийн эрх байхгүй байгаагаас кассын төлбөртэй үйлчилгээний орлогоос зарцуулалт хийж, дараа нь харилцах данснаас нөхөн дүүргэлт хийж байгаа нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.10 дахь заалтад “Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана;” гэж

заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах талаар журам боловсруулж мөрдөх

Илрүүлэлт2:

Нэгдсэн эмнэлгийн мөнгөн кассын орлогыг төрийн сангийн харилцах дансанд хэрхэн тушаасныг шалгаж үзэхэд өдөр алгасаж тушаах тохиолдол гарсан нь “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.10 дахь заалтад “Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана,” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Мөнгөн касс хүлээж авсан бэлэн мөнгөний орлогыг дараагийн ажлын өдөрт багтааж, бүрэн тушааж хэвших

#### **4. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас нэг удаагийн шинжтэй 9,406.6 мянган төгрөгийн шагнал урамшуулал гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх.

#### **5. Дотоод хяналтын талаар**

Илрүүлэлт:

Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 16 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц орон тоог батлахдаа өмнө нь бие даасан, гүйцэтгэх захиралд ажлаа шууд тайлагнадаг байсан дотоод хяналт, аудитын албыг Чанар аюулгүй байдал, дотоод албанд харъяалуулж, ажлаа тус албаны даргад тайлагнадаг болсон байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.2 заалтад “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод хяналтыг хараат бусаар үр дүнтэй зохион байгуулах.

#### **6. Худалдан авах ажиллагааг төлөвлөхтэй холбоотой**

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд эм, эмнэлгийн хэрэгслийг бүхэлд нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тусгаж, ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авахаар тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна.” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа эмийг ерөнхий гэрээний аргаар худалдаж авахаар тусгах

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Завсрын аудитаар:</b>										
Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой	3	9,220.8			3	9,220.8	3	9,220.8		
Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой	1	3,401.0			1	3,401.0	1	3,401.0		
Цалин бодолт, бүртгэлтэй холбоотой	3	23,800.2			3	23,800.2	3	23,800.2		
Бараа материалын бүртгэлтэй холбоотой	1	5,092.6			1	5,092.6	1	5,092.6		
Шилэн данстай холбоотой	3	-			3	-	3	-		
<b>Завсрын аудитын дүн</b>	<b>11</b>	<b>41,514.6</b>			<b>11</b>	<b>41,514.6</b>	<b>11</b>	<b>41,514.6</b>		
<b>Жилийн эцсийн аудитаар:</b>										
Батлагдсан маягтын дагуу тайланг бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	0.0	1	0.0			1	0.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,264.6</b>		<b>-</b>	<b>1</b>	<b>1,264.6</b>	<b>1</b>	<b>1,264.6</b>		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1	9,406.6					1	9,406.6
2023 онд актлахаар шийдвэр гаргасан эмийг тухайн үед актлаагүй, 2025 онд акталснаар бүртгэсэн.	1	3,108.2					1	3,108.2
Жижиг мөнгөн сангийн зарцуулалтын журам боловсруулж, мөрдөөгүй	1	4,685.7					1	-
Мөнгөн кассын бэлэн мөнгөний орлогыг ажлын дараа өдөрт багтааж төрийн сангийн харилцах дансанд тушаагаагүй	1	-					1	-
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	-					1	-
Бараа материалын орлого, зарлага, буцаалтыг тухай бүрд нь хийгээгүйгээс тооллогоор эм илүүдсэн.	1	3,990.4					1	3,990.4
1 жилээс дээш хугацаанд ашиглах хөрөнгийг картлаагүй	1	6,347.5					1	6,347.5
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд эмийн худалдан авалтыг ерөнхий гэрээний аргаар худалдаж авахаар тусгаагүй	1	-					1	-
Дотоод хяналтыг хараат бусаар зохион байгуулаагүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>27,538.4</b>					<b>9</b>	<b>27,538.4</b>

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

